

Газар эзэмшил, ашиглалтын талбайн хэмжээ,
зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтад заагдсан нэр бүхий 16 /арван зургаа/ иргэний газар эзэмшил, ашиглалтын талбайн хэмжээ, зориулалт өөрчлөхийг хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2004 оны 38 дугаар захирамжийн Мижид Болдбаяр, 2003 оны 165 дугаар захирамжийн Лувсанжигмэд Цэцэгмаа, 2013 оны A/232 дугаар захирамжийн Насанхүү Энхцэцэг, 2008 оны 150 дугаар захирамжийн Дамдин Анхбаяр, 2017 оны A/329 дүгээр захирамжийн Дэмбэрэл Лхагва, 2006 оны A/84 дүгээр захирамжийн Дэмбэрэл Лхагва, 2007 оны 151 дүгээр захирамжийн Адъяа Ганхүү, 2016 оны A/740 дүгээр захирамжийн Сүх Байгал, 2016 оны A/730 дугаар захирамжийн Сүх Сайнтэгш, 2000 оны захирамжийн 010610535 дугаар гэрчилгээтэй Дулам Бибат, 2016 оны A/517 дугаар захирамжийн Дагва Ганбат, 2010 оны A/252 дугаар захирамжийн Аюуш Оюунханд, Сэрвүү Багаажав, Багаажав Наранцэцэг, Гөлгөө Эрдэнэцэцэг, Лүндэндорж Дүйнхэржав нарт холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрхийн талбайн хэмжээ өөрчилсөн иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ